



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын өдөр

Дугаар 0/686

Улаанбаатар хот

**Сонгинохайрхан дүүргийн 127 дугаар  
цэцэрлэгийн балансас  
хөрөнгө шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2019 оны 12 дүгээр сарын 23-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 3,115,000.0 /гурван сая нэг зуун арван таван мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Сонгинохайрхан дүүргийн 188 дугаар цэцэрлэгийн балансд шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Сонгинохайрхан дүүргийн 127 дугаар цэцэрлэг /А.Энхцэцэг/-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Сонгинохайрхан дүүргийн 188 дугаар цэцэрлэг /Н.Мөнхцэцэг/-т даалгасугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Сонгинохайрхан дүүргийн 188 дугаар цэцэрлэг /А.Энхцэцэг/, Сонгинохайрхан дүүргийн 127 дугаар цэцэрлэг /Н.Мөнхцэцэг/-т тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын  
газрын даргын 2019 оны 12 дугаар  
сарын 22 өдрийн 4/1 тоот тушаалын хавсралт  
4/186

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн 127-р цэцэрлэг

| №                                   | Эд хөрөнгийн нэр      | Ашиглалтад<br>орсон он | Чанар | Хэмжих<br>нагж | Тоо ширхэг | Нэгжийн үнэ | Бүгд үнэ         | Хуримтлагдсан<br>элэгдэл | Хөрөнгө хүлээн<br>авагч байгууллага          |
|-------------------------------------|-----------------------|------------------------|-------|----------------|------------|-------------|------------------|--------------------------|--|
| 1                                   | Монгол гэр иж бүрэн   | 2017                   | Сайн  | ш              | 1          | 2,550,000   | 2,550,000        | 2,550,000                | Сонгинохайрхан<br>дүүргийн 188-р<br>цэцэрлэг |
| 2                                   | Хөнжил гудасны шкаф   | 2017                   | Сайн  | ш              | 1          | 400,000     | 400,000          | 400,000                  |  |
| 3                                   | Хөнжил гудасны шүүгээ | 2016                   | Сайн  | ш              | 1          | 165,000     | 165,000          | 165,000                  |  |
| <b>Машин тоног төхөөрөмжийн дүн</b> |                       |                        |       |                |            |             | <b>3,115,000</b> | <b>3,115,000</b>         |  |
| <b>Нийт дүн</b>                     |                       |                        |       |                |            |             | <b>3,115,000</b> | <b>3,115,000</b>         |  |